



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын газрын
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан хоёр аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан гурав иргэн, аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Итгэлт түнш ХХК "Ланд" зочид буудлын 13/97, Жи Эн И Дабль Ю ХХК "Хан" зочид буудлын 13/226, Шанд батос ХХК "Армо" дэн буудлын 14/68, Иргэн С.Саруултуяа "Z" дэн буудлын 13/180, Малик Трейд ХХК "Агате" дэн буудлын 15/095 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

5. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.БАТСҮХ

1150500030

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 01 сарын 18
өдрийн А/дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ


2017.01.18

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Итгэлт түнш ХХК	2791293	Ланд зочид буудал	Баянгол дүүрэг, 16-р хороо, Амарсанаагийн гудамж 54
2	Жи Эн И Дабль Ю ХХК	5163617	Хан зочид буудал	Баянгол дүүрэг, 8-р хороо, Жамсранжавын гудамж 3-р байр

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 01 сарын 19
өдрийн А/10 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.01.18

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Малик Трейдинг ХХК	5524679	Агатэ	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бээжингийн гудамжны 13-р байрны 3-р давхарт
2	Шанд батос ХХК	5430003	Армо дэн буудал	Баянгол дүүрэг, Хасбаатарын гудамж 1/8 тоот
3	Иргэн С.Саруултуяа	Мф70061603	Z дэн буудал	Баянгол дүүрэг, 17-р хороо, Дамдинбазарын гудамж 7/1 тоот

-ooOoo-